

Газрын тосны хайгуулын Хар-Ус II талбайн танилцуулга

Газрын тосны хайгуулын Хар-Ус II талбайн танилцуулга	
Талбайн нэр	Газрын тосны хайгуулын Хар-Ус II талбай
Байршил	Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Ховд, Чандмань, Манхан, Зэрэг, Мөст, Дарви, Дөргөн сумын нутагт
Талбайн хэмжээ	27409,33 км.кв
Хайгуулын хугацаа	Газрын тосны тухай хуулийн 18.4-т заасны дагуу 8+2+2=12 жил
Ашиглалтын хугацаа	Газрын тосны тухай хуулийн 25.2-т заасны дагуу 25+5+5=35 жил
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Хар Ус II талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах
Гэрээ байгуулах явц	ХарУс-II талбайд 2007 онд нээлттэй тендер зарласан бөгөөд уг сонгон шалгаруулалтад “Реноваилч” ХХК шалгарч Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 3 дугаар сарын 3-ний өдрийн 44 дүгээр тушаалаар Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг тус компанитай хэлэлцэн тохиролцож үзэглэх эрхийг Газрын тосны газарт олгосон. Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар гэрээний төслийг 2014.07.09-нд үзэглэн УУЯ-нд хүргүүлж, бусад яамдаас санал авч байна.
Хууль эрх зүйн орчин	<ul style="list-style-type: none"> - Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 7.1.8-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг МУ-ын ЗГ шийдвэрлэнэ. - Газрын тосны тухай хуулийн 8.1.4-д заасны дагуу Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу УУЯ хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлана. - Газрын тосны тухай хуулийн 9.1.2-д заасны дагуу Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Газрын тосны газар нь хайгуулын талбайд захиалга хүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, энэ хуулийн 7.1.8-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулна. - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.18-д заасны дагуу УУЯ нь газрын тос хайх тусгай зөвшөөрлийг олгоно. - Газрын тосны тухай хуулийн 18.11-д заасны дагуу Төрийн захиргааны байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ. - Газрын тосны тухай хуулийн 11.2.3-д заасны дагуу тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг ГТГ-аар батлуулж, хайгуулын ажлыг эхлүүлнэ.

<p>Орон нутгийг хөгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтын үндсэн үзүүлэлт болох Газрын тосны тухай хуулийн 17.3.10-д заасан орон нутгийг хөгжүүлэх урамшуулалд “Ренова илч” ХХК нь 25,000 ам.долларыг жил бүр төлнө. - Газрын тосны тухай хуулийн 31.3-д заасны дагуу Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ. - Газрын тосны тухай хуулийн 30.6-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сум, дүүргийн төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна. - Газрын тосны тухай хуулийн 11.2.17-д заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах бөгөөд хуулийн 7.1.13-д заасны дагуу уг гэрээний загварыг ЗГ батална.
<p>Хөрөнгө оруулалт</p>	<p>Гэрээлэгч газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардал, эрсдлийг 100 хувь өөрөө хариуцна.</p>
<p>Хайгуулын хугацааны хөрөнгө оруулалтын хэмжээ</p>	<p>Хайгуулын 8 жилийн хугацаанд нийт 38,9 сая ам.долларын хөрөнгө оруулна.</p>
<p>Гэрээний эхний жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ</p>	<p>БХГ-ний хайгуулын шатны эхний жилд 4,5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ.</p>
<p>Гэрээг хэрэгжүүлснээр гарах үр дүн</p>	<p>Гэрээлэгч тос олсон тохиолдолд борлуулалт хийсэн тухай бүрт гэрээт тосноос тооцож роялти төлнө. Роялти нь нийт олборлосон гэрээт түүхий тосны 10%-тай тэнцүү байх ба бэлэн мөнгөөр эсвэл тосоор төлнө. Тухайн жилд олборлосон тосноос роялтийг хасаад үлдэх тосны 40% нь өртөгт тос болох бөгөөд олборлосон тосноос роялти, өртөгт тосыг хасаад үлдэх тосыг МУ-ын ЗГ болон Гэрээлэгчийн хооронд хуваах хуваалтөдрийн дундаж олборлолтын хэмжээ 5000 баррель, түүнээс бага байвал 45%:55%, 5001-10000 баррель байвал 50%:50%, 10001-15000 баррель байвал 55%:45%, 15001-20000 баррель байвал 60%:40%-иар тус тус хуваарилна.</p>